



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/97

Жаргалтхаан

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.3, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.2.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус суманд 2024 онд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй “Соёлын төвд угсардаг сандал нийлүүлэх” ажлын гүйцэтгэлийн явцад хяналт тавих, хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Т.Сүрэнцэцэг –Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Ж.Ариунгэрэл- Соёлын төвийн даргын албан

үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Э.Эрдэнэхүү – Санхүүгийн албаны дарга

Б.Чинбат- Иргэний танхимын ажилтан

(зөвшилцсөнөөр)

Г.Жавзанжамъян - Нярав

2.Дээрх ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд нь чанартай гүйцэтгүүлж холбогдох хууль журмын дагуу хүлээн авч, дүгнэлт гаргаж ажиллахыг ажлын хэсэг (Т.Сүрэнцэцэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ЦЭНГЭЛ

Data (D:) /A4 zahiramj/

232401235